

# “ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дугаар  
сарын 28-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

*Хурлын ирцийг батлах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

“Эм Эн Ди” ХК-ийн нийт: 97,360 саналын эрхтэй энгийн хувьцааны 72,265 хувийг эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигч оролцсон учир хурлыг хүчин төгөлдөрт тооцох саналын хувь бүрдсэн гэж үзэн хурлыг хүчинтэйд тооцсугай.

Хурлын ирц хангалттай тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хурлын дэгийн дагуу явуулахыг зөвшөөрсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИСС:  
КОМИССЫН ДАРГА



Б.СҮНЧИГМАА

# “ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дугаар  
сарын 28-ны өдөр

№ *AL*

Улаанбаатар хот

*ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах тухай:*

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн “Эм Эн Ди” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь: “Эм Эн Ди” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг сунгасугай.

Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр:

1. Намсрайн Отгон-Од
2. Пионг Чунг Фах (Piong Choong Fah)
3. Чунг Чии Иенн (Chung Chee Yenn)
4. Лю Вен Тейк (Lew Wen Teik)
5. Намсрайн Ганчимэг
6. Н.Гансувд

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:

1. Цэрэндоржын Болд
2. Н.Ганбаатар
3. Баяр-эрдэнэгийн Сарнай

Дараах бүрэлдэхүүнтэйгээр хороодыг томилсугай.

1. Нэр дэвшүүлэх хорооны даргаар Ц.Болд, гишүүнээр Н.Отгон-Од, Н.Гансувд
2. Цалин, урамшууллын хорооны даргаар Н.Отгон-Од гишүүнээр Ганбаатар, Б.Сарнай
3. Аудитын хорооны даргаар Н.Гансувд, гишүүнээр Н.Отгон-Од, Б.Сарнай нэрийг томилсугай.

“Эм Эн Ди” Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг компанийн үйл ажиллагаа сайжирч, компани ашигтай ажиллаж эхлэсэн хугацаанаас ТУЗ-ийн цалин урамшууллыг дахин хэлэлцүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



/Н.ГАНЧИМЭГ/

# “ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дугаар  
сарын 28-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

*Компанийн жилийн үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайлангийн  
талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн  
дүгнэлт, хараат бус аудитын  
дүгнэлтийг батлах тухай*

“ЭМ ЭН ДИ” Хувьцаат компанийн 2021 оны жилийн үйл ажиллганы болон санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцэн баталж, Компанийн тухай хуулийн 62.1.9 дэхь заалт, 46 дугаар зүйлийн 6 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн талаархи төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн ноогдол ашиг тараахгүй болохыг тэмдэглэсүгэй.
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 онд хийсэн ажлыг хангалттай гэж тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Н.ГАНЧИМЭГ/

# “ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дугаар  
сарын 28-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

*Гүйцэтгэх захирлын бүрэн эрх,  
цалин урамшуулал*

Компанийн тухай хуулийн 62 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Тус компанийн Гүйцэтгэх захирал Намсрайн Отгон-Од-ын бүрэн эрхийг сунгаж, үргэлжлүүлэн ажиллуулах бөгөөд цалин урамшууллын хэмжээг компанийн үйл ажиллагаа сайжирч, компани ашигтай ажиллаж эхлэсэн хугацаанаас Төлөөлөн удирдах зөвлөл дахин хэлэлцэхээр тогтсугай.

ХУРЛЫН ДАРГА



/Н.ГАНЧИМЭГ/